

Хэрхэн ажлын эрхийн өргөдөл гаргах

Та Швед улсад ажиллахад зайлшгүй ажлын эрхтэй байх ёстой. Хэрвээ та 3 сараас бага хугацаагаар явж байгаа бол танд виз хэрэгтэй, мөн 3 сараас дээш хугацаагаар явж байгаа бол оршин суух эрх хэрэгтэй болно.

Ажлын эрхийг 2 болон түүнээс доош жилийн хугацаагаар өгдөг. 2 жилийн дараа эрхийг дахин 2 жилээр сунгах боломжтой. 4 жилийн (48 сар) ажлын эрхийн дараа оршин суух буюу амьдрах эрх хүсэх эрхтэй. Эхний 2 жил ажлын эрх тодорхой нэг мэргэжлээр тодорхой нэг ажил олгогч дээр ажиллахад хүчинтэй. 2 жилийн дараа ажлын эрх зөвхөн тодорхой мэргэжилд хамаатай.

Нэмэлт мэдээлэл, шинэ хууль дүрмийг Шведийн Цагаачлалын албаны өөрийнх нь вэб-сайтаас олох боломжтой. www.migrationsverket.se

Та ажлын эрхийн өргөдлөө Шведийн элчин сайдын яам эсвэл Ерөнхий Консулын газар өгөх ёстой. Таны өргөдлийг хүлээн авсны дараа таныг магадгүй хувийн ярилцлагад дуудах болно. Элчин сайдын яам бүх бичиг баримтыг бүрдсэний дараа хавтаст хуудсыг Швед улсын Цагаачлалын алба руу шилжүүлэх болно. Мөн өргөдлийг цахим хэлбэрээр шууд Шведийн Цагаачлалын алба руу илгээж бас болно. Хэрвээ Шведийн Цагаачлалын алба нааштай хариу гаргасан бол тэд танд оршин суух карт үйлдвэрлэн элчин сайдын яам руу илгээх болно. Элчин сайдын яаманд таны карт ирсэн тохиолдолд тэд тантай холбоо барих бөгөөд та ирж авах боломжтой.

Таны анхааралд: Хэрвээ та өргөдлөө шуудангаар эсвэл цахим хэлбэрээр явуулсан бол та заавал элчин сайдын яам эсвэл Консулын газар очиж биометр-ээ Цагаачлалын албанд оршин суух карт хийлгэхэд зориулан үлдээх ёстой.

Таны өргөдөлд хэрэгцээтэй бичиг баримтууд (Таны анхааралд: та өргөдөлд орж байгаа бүх бичиг баримтыг 1 хувь хуулбартай өгөх ёстой).

Мөн Цагаачлалын алба болон элчин сайдын яамнаас асуугаагүй бичиг баримт өгөхгүй байна уу.

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.
- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй болон энэ нь өргөдөл шийдэх явцыг удаашруулах магадлалтай.
- паспортын нүүр хуудас харуулсан хуулбар 2 хувь. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол улсын иргэдэд:** Хэрвээ Монгол улсын иргэд оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо элчин сайдын яам руу илгээхгүй байх хэрэгтэй, мөн таны өргөдлийг нааштай шийдсэн тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биометр-ээ үлдээх ёстой.
- Ажил олгогчоор “Хөдөлмөр эрхлүүлэх санал” маягтыг бөглүүлж, мөн орон нутгийн үйлдвэрчний эвлэлийн байгууллагаар гарын үсэг зуруулсан байх шаардлагатай. Маягт нь “Anställningserbjudande 232011” бөгөөд үүнийг Шведийн Цагаачлалын албаны вэб-сайтаас олж болно.
- Та өргөдлийн төлбөр төлсөн байх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгвөл төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр одоогоор **2030 юань** бөгөөд элчин сайдын яам зөвхөн картын тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлсэн бол заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Та өргөдлөө Швед улс руу явахаас дор хаяж 10 долоо хоногийн өмнө Шведийн элчин сайдын яаманд өгсөн байх ёстой. Хэрвээ шаардсан бичиг баримт бүрэн хангагдаагүй бол шийдвэр гаргах явц магадгүй удааширна. Элчин сайдын яаманд нэмэлт бичиг баримт болон лавлах мэдээлэл хэрэгтэй бол тантай холбогдоно.

Та анкетан дээрээ тантай эргээд холбогдох мэдээллийг бичиж үлдээх нь чухал. Үлдээгээгүй тохиолдолд элчин сайдын яам таны анкеттай холбоотой шаардлагатай бичиг баримтыг танаас шаардах, эсвэл бусад тантай холбоотой асуудлыг танд мэдэгдэж чадахгүй болно.

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Шведийн элчин сайдын яам эсвэл Цагаачлалын албаны вэб-сайтыг харна уу. www.migrationsverket.se

Ажиллах эрхтэй хүнийг дагалдан оршин суух эрхийн хүсэлт гаргах

Хэрвээ та өөрийн нөхөр/эхнэр/хамтран амьдрагчтай хамт Швед улсад хязгаартай хугацаагаар амьдрах төлөвлөгөөтэй бол та Швед улс руу зорчихоос өмнө оршин суух эрхийн өргөдлөө гаргах ёстой.

Та тус эрхийг Бээжинд байрлах Шведийн элчин сайдын яамнаас хүсэж болно. Элчин сайдын яам танаас шаардлагатай бичиг баримтыг авсны дараа таны өргөдлийг Швед улсын Цагаачлалын алба руу илгээнэ.

Шведийн Цагаачлалын алба нааштай хариу гаргасан тохиолдолд тэд оршин суух карт үйлдвэрлэн элчин сайдын яам руу явуулна. Элчин сайдын яаманд карт ирсэн тохиолдолд тэд тантай холбоо барих бөгөөд та ирж картаа авах боломжтой. **Та үүнээс өмнө Швед улс руу зорчиж, хариуг тэнд хүлээж болохгүй.**

Таны өргөдөлд доорх бичиг баримт орох шаардлагатай (таны анхааралд: та хавсаргаж буй бичиг баримтаа тус бүрийг 1 хувь хуулбартай нь өгөх ёстой).

Мөн Цагаачлалын алба эсвэл Элчин сайдын яамнаас шаардаагүй бичиг баримт өгөхгүй байна уу.

Хэрвээ таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагч Шведэд амьдардаг бол

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.
- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй ба энэ нь таны өргөдөл шийдэгдэх явцыг удаашруулах магадлалтай.
- 2 хувь паспортын нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол улсын иргэдэд:** Хэрвээ Монгол улсын иргэн оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо элчин сайдын яам руу илгээхгүй байна уу, мөн таны өргөдөл нааштай шийдэгдсэн тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биометр-ээ үлдээх ёстой.
- Нотариатаар баталгаажуулсан гэрлэлтийн гэрчилгээ, мөн гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, эсвэл та Швед улсад гэрлэсэн бол шведийн гэрлэлтийн гэрчилгээг (vigselsevis) 2 хувиар өгнө. *Монгол улсын иргэд бичиг баримтыг Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулж өгөх ёстой.*
- Хэрвээ та гэрлэж байгаагүй эсвэл салсан бол өөрийг тань ганц бие гэдгийг харуулсан нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ байх ёстой (эх хувь болон англи хэл дээрх орчуулга). Энэ нь гэрчилгээ байх ёстой, тодорхойлолт эсвэл мэдэгдэл байж болохгүй. *Монгол улсын иргэдэд: Бичиг баримтыг Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулсан байх шаардлагатай.*
- таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчийн паспортын нүүр хуудсын 2 хувь.
- таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчийн хүн амын бүртгэлийн гэрчилгээ " personbevis" 2 хувь.
- нөхөр/эхнэр/хамтран амьдрагчийн урилга
- хувиараа ажил эрхэлж байгаа хүний дагалдагчаар зөвшөөрөл хүсч байгаа бол санхүүгийн баталгаа байх шаардлагатай. Та анхны жилдээ сар болгон 3500 швед кронтой гэдгээ харуулах хэрэгтэй.
- Та өргөдлийн төлбөр төлөх шаардлагатай. Хэрвээ та өргөдөлдөө татгалзсан хариу авбал төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр одоогоор **1015 юань** бөгөөд Элчин сайдын яам зөвхөн картын тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Шуудангаар мөнгө ирүүлсэн тохиолдолд заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулсан байх шаардлагатай.

Эцэг эхийн аль нэг эсвэл хоёулаа Шведэд байгаа (18-аас доош насны) хүүхэд, эсвэл эцэг эхээ дагалдан Швед рүү явах хүүхэд

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.

- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй болон энэ нь өргөдөл шийдэх явцыг удаашруулах магадлалтай.
- 2 хувь паспортны нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол иргэдэд:** *Хэрвээ Монгол улсын иргэн оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо Элчин сайдын яам руу илгээхгүй байна уу, мөн өргөдөл нааштай шийдэгдсэн тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биомэтр-ээ үлдээх ёстой.*
- Нотариатаар баталгаажуулсан төрсний гэрчилгээ, гэрчилгээний хуулбарын хамт. *Монгол улсын иргэд бичиг баримтыг Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулсан байх ёстой.*
- Хэрвээ хүүхдийн эцэг эхийн нэг нь албан ёсны харгалзагч бол үүнийг батласан нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ, хуулбарын хамт. *Монгол улсын иргэд бичиг баримтыг Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулсан байх шаардлагатай.*
- Хүүхдийн харгалзагчдын нэг нь Монголд үлдэж байгаа тохиолдолд тухайн харгалзагч хүүхдийг Швед улс руу амьдрахаар явж байгааг мэдэж байгаа, Швед улс руу явахыг нь зөвшөөрч байгаа гэсэн нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ, тус гэрчилгээний нэг хуулбартай. *Монгол улсын иргэд бичиг баримтыг Улаанбаатар дахь Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулсан байх шаардлагатай.*
- Шведэд байгаа эцэг эхийн паспортны нүүр хуудасны хуулбар 2 хувь.
- Шведэд байгаа эцэг эхийн хүн амын бүртгэлийн гэрчилгээ "personbevis" 2 хувь.
- Шведэд байгаа эцэг эхийн урилга.
- Швед байгаа хүн хувиараа ажил эрхэлж байгаа бол дагалдагч санхүүгийн баталгаа гаргана. Та анхны жилд сар болгон 2100 швед крон ашиглах боломжтойгоо харуулах хэрэгтэй.
- Та өргөдлийн төлбөр төлсөн байх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгвөл төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр 18-аас доош насны хүүхдийн хувьд одоогоор **505 юань** бөгөөд Элчин сайдын яам зөвхөн картаар тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохилдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлбэл заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Хэрвээ шаардсан бичиг баримтыг бүрэн өгөөгүй бол таны шийдвэр гарах явц магадгүй удааширна. Элчин сайдын яамнаас нэмэлт бичиг баримт болон лавлах мэдээлэл хэрэгтэй бол тантай холбогдоно.

Та өргөдөлдөө тантай эргээд хэрхэн холбогдох мэдээллийг бичиж үлдээх нь чухал. Үлдээгээгүй тохиолдолд Элчин сайдын яамнаас таны өргөдөлтэй холбоотой нэмэлт бичиг баримт шаардах, эсвэл бусад тантай холбоотой асуудлыг тэд мэдэгдэх боломжгүй болно.

Гэр бүлийн хамаарлаар оршин суух эрх хүсэх тухай нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Элчин сайдын яамтай холбогдох, эсвэл Шведийн Цагаачлалын албаны өөрийнх нь вэб-сайтаас харах боломжтой.
www.migrationsverket.se

Хэрхэн гэр бүлийн хамаарлаар оршин суух эрх хүсэх

Хэрвээ та Швед улсад нөхөр/эхнэр/хамтран амьдрагч/хүүхэд/ойрын хамаатантайгаа байнга оршин суух хүсэлтэй бол та Швед улс руу явахаасаа өмнө оршин суух эрх хүсэх ёстой. Та хүсэлтийг Бээжин дахь Шведийн элчин сайдын яаманд гаргаж болно. Та Швед улс руу зорчин тэндээ хариуг хүлээж болохгүй.

Хэрвээ таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагч/эцэг эх Швед улсад түр хугацаагаар ажиллаж байгаа эсвэл сурч байгаа бол та түүнийг дагалдагч журмаар өргөдөл гаргаж болно. Холбоотой мэдээллийг эндээс харна уу:

>Оюутанд дагалдагчаар өргөдөл гаргах

>Ажиллаж байгаа хүнд дагалдагчаар өргөдөл гаргах

Хэрвээ та гэр бүлийн хамт Швед улсад суурьшихаар төлөвлөж байгаа бол, Элчин сайдын яам таны өргөдлийг хүлээж авсны дараа таныг хувийн ярилцлагад дуудна. Элчин сайдын яам бичиг баримт бүрдсэний дараа хавтаст хэргийг Швед улсын Цагаачлалын алба руу шилжүүлнэ. Мөн Швед улсад амьдарч байгаа таны гэр бүлийн хүн/хамаатан садан ярилцлагад дуудагдана. Таны өргөдөлд шийдвэр

гаргах эрх мэдлийн байгууллага бол Шведийн Цагаачлалын алба юм. Хэрвээ Шведийн Цагаачлалын алба танд нааштай хариу гаргавал танд оршин суух эрхийн карт үйлдвэрлэн элчин сайдын яам руу илгээнэ. Элчин сайдын яаманд таны карт ирсэн тохиолдолд тэд тантай холбоо барих бөгөөд та ирж картаа авах боломжтой.

Онлайнаар анкет бөглөх үйлчилгээ

2011-12-07-ноос эхлэж Швед улсын бүх элчин сайдын яамд дээр гэр бүлийн хамаарлаар оршин суух эрхийн өргөдлийг онлайнаар гаргах үйлчилгээ бий болсон. Энэ шинэ үйлчилгээг Шведийн Цагаачлалын алба хариуцаж байгаа бөгөөд энэ нь өргөдөл боловсруулах үйл ажиллагааг хялбаршуулж байгаа юм. Нэмэлт мэдээллийг дараах вэб-сайтаас олох боломжтой.

http://www.swedenabroad.com/Page_134077.aspx

Таны өргөдөлд дараах бичиг баримт орох ёстой. (Таны анхааралд: хавсаргах бүх бичиг баримт тус бүр нэг хуулбартай өгөгдөх ёстой.)

Мөн Цагаачлалын алба болон Элчин сайдын яамнаас шаардагдаагүй бичиг баримт өгөхгүй байна уу.

Хэрвээ таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагч Шведэд байгаа бол

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.
- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй гэр бүлийн нарийвчилсан маягт.
- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй болон энэ нь өргөдөл шийдэх явцыг удаашруулах магадлалтай.
- 2 хувь паспортын нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол иргэдэд:** Хэрвээ Монгол улсын иргэд оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо Элчин сайдын яам руу илгээхгүй байх хэрэгтэй, мөн таны өргөдөл нааштай шийдэгдсэн тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биометр-ээ үлдээх ёстой.
- Нотариатаар баталгаажуулсан гэрлэлтийн гэрчилгээ, гэрчилгээний нэг хувь хуулбар, та Швед улсад гэрлэсэн бол шведийн гэрлэлтийн гэрчилгээ (vigselbevis) 2 хувиар өгнө. *Монгол улсын иргэд бичиг баримтыг Гадаад явдлын яамаар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- Хэрвээ та гэрлэж байгаагүй эсвэл гэр бүлээ цуцлуулсан бол таныг ганц бие гэдгийг харуулсан нотариатын гэрчилгээ (эх хувь, англи хэлний орчуулгын хамт). Энэ нь тодорхойлолт, мэдэгдэл биш, харин гэрчилгээ байх ёстойг анхаарна уу. *Монгол иргэдийн анхааралд: Бичиг баримтыг Гадаад явдлын яамаар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулах ёстой.*
- таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчийн паспортын нүүр хуудасны хуулбар 2 хувь.
- таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчийн хүн амын бүртгэлийн гэрчилгээ "personbevis" 2 хувь. Уг гэрчилгээ танд хамаатай мэдээллийг агуулах ёстой, жишээ нь: хэрвээ та хоёр гэрлэсэн бол гэрчилгээн дээр энэ тухай бүртгэл байх ёстой.
- Та өргөдлийн төлбөр төлөх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгвөл төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр одоогоор **1525 юань** бөгөөд Элчин сайдын яаманд зөвхөн картаар тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлбэл заавал хятад мөнгөн тэмдэгт байх ёстой бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Эцэг эхийн аль нэг нь эсвэл 2-уулаа Шведэд байгаа (18-аас доош насны) хүүхэд эсвэл эцэг эхээ дагалдан Швед улс руу явж байгаа хүүхэд:

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.
- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй гэр бүлийн маягт.
- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй болон энэ нь өргөдөл шийдэгдэх явцыг удаашруулах магадлалтай.
- 2 хувь паспортын нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол улсын иргэдэд:** Хэрвээ Монгол улсын иргэд оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо элчин сайдын яам руу илгээхгүй байна уу, мөн таны өргөдөл нааштай шийдэгдсэн нөхцөлд заавал өөрийн биеэр Элчин сайдын яаманд ирж биометр-ээ үлдээнэ үү.

- Нотариатаар баталгаажуулсан төрсний гэрчилгээ, төрсний гэрчилгээний хуулбар. *Монгол улсын иргэдэд: бичиг баримтыг Улаанбаатар дахь Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- Хэрвээ хүүхэд ганц харгалзагчтай бол хүүхдийн албан ёсны харгалзагч хэн болохыг заасан нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ, мөн гэрчилгээний хуулбар. *Монгол улсын иргэдэд: бичиг баримтыг Улаанбаатар дахь Гадаад явдлын яамаар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- Хүүхдийн аль нэг харгалзагч Монголд байгаа тохиолдолд хүүхэд Швед улс руу амьдрахаар явж байгааг мэдэж байгаа, хүүхдийг Швед улс руу явахыг зөвшөөрч байна гэсэн нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ шаардлагатай. *Монгол улсын иргэд бичиг баримтыг Улаанбаатар дахь Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- эцэг эхийн паспортын нүүр хуудасны хуулбар 2 хувь.
- Швед улсад амьдарч буй эцэг эхийн хүн амын бүртгэлийн гэрчилгээ, "personbevis". Энэ гэрчилгээн дээр хүүхдийн эцэг эхийг заасан байх ёстой. Энэ гэрчилгээг мөн "familjebevis" гэнэ.
- Та өргөдлийн төлбөр төлөх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгвөл төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр 18-аас доош насны хүүхдэд **760 юань** байгаа бөгөөд элчин сайдын яам зөвхөн картаар тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлбэл заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Та Швед улс руу хүүхэд эсвэл хамаатан садан руугаа зочлох бол:

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.
- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй гэр бүлийн маягт.
- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй болон энэ нь өргөдөл шийдэгдэх явцыг удаашруулах магадлалтай.
- 2 хувь паспортны нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол улсын иргэдэд:** *Хэрвээ Монгол улсын иргэд оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо элчин сайдын яам руу илгээхгүй байна уу, мөн таны өргөдөл нааштай шийдэгдсэн тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биометр-ээ үлдээнэ үү.*
- Уригч тал уригдагч талтай ямар харьцаатай, хүүхэд /эцэг эх/ хамаатны г.м., гэдгийг харуулсан нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ, мөн гэрчилгээний хуулбар. *Монгол улсын иргэдэд: бичиг баримтаа Улаанбаатар дахь Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- Уригчийн паспортын эхний нүүр хуудасны хуулбар 2 хувь.
- Уригчийн хүн амын бүртгэлийн гэрчилгээ "personbevis" 2 хувь.
- та Швед улсад байгаа хамаатан саднаасаа хамааралтай гэдгийг баталсан бичиг баримт.
- та өргөдлийн төлбөр төлсөн байх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгвөл төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр **1015 юань** бөгөөд элчин сайдын яаманд зөвхөн картаар тооцоо хийнэ. Өргөдлийн төлбөр 18-аас доош насны хүүхдэд одоогоор **505 юань** байгаа бөгөөд элчин сайдын яам зөвхөн картаар тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлбэл заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Шаардсан бичиг баримт бүрэн ирээгүй нөхцөлд шийдвэр гаргах явц магадгүй удааширна. Элчин сайдын яамнаас нэмэлт бичиг баримт болон лавлах мэдээлэл хэрэгтэй бол тантай холбогдоно.

Та анкет дээрээ тантай эргээд холбогдох мэдээлэл бичиж үлдээх нь чухал. Үлдээгээгүй тохиолдолд элчин сайдын яамнаас таны өргөдөлтэй холбоотой нэмж бичиг баримт шаардах эсвэл бусад тантай холбоотой асуудлыг танд мэдэгдэж чадахгүй болно.

Гэр бүлийн хамаарлаар оршин суух эрх хүсэх тухай нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл элчин сайдын яамтай холбогдох эсвэл Шведийн Цагаачлалын албаны өөрийнх нь вэб-сайтаас харах боломжтой.

www.migrationsverket.se

Тайлбар: Та хувийн ярилцлагад орохдоо итгэмжлэл гаргах эрхтэй. Та итгэмжлэлийн анкет бөглөснөөр таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагч таны өргөдөлтэй холбоотой бүх төрлийн асуултанд Цагаачлалын албанд хариу өгөх боломжтой. Мөн Цагаачлалын алба таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчид таны шийдвэрийг мэдэгдэнэ, мөн танд татгалзсан хариу ирвэл таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагч даван заалдах боломжтой.

Шведэд суралцах журмаар оршин суух эрх хүсэх

Хэрвээ та Швед улсад 3-аас дээш сарын хугацаагаар сурах бол заавал оршин суух эрхтэй байх ёстой. Хэрвээ 3-аас доош сарын хугацаагаар сурах бол зөвхөн визтэй байхад хангалттай байж болно. Та доор дурдсан бичиг баримтыг анкетын хамт Шведийн элчин сайдын яаманд өгөх ёстой.

Та Элчин сайдын яам дээр өөрийн биеэр ирж хүсэлтээ тавих ёстой. Та ямар нэгэн зуучлах товчоогоор дамжуулж хүсэлтээ тавьж болохгүйг анхаарна уу. Мөн та анкетан дээрээ ямар нэгэн зуучлагчийн биш, өөртэйгээ эргээд холбоо барих мэдээллийг үлдээх хэрэгтэй.

Хэрвээ элчин сайдын яам шаардлагатай гэж үзвэл таныг хувийн ярилцлагад дуудна. Элчин сайдын яам таны хавтаст хэргийг Швед улсын Цагаачлалын алба руу шийдвэр гаргуулахаар шилжүүлнэ. Швед улсын Цагаачлалын алба таны өргөдөлд нааштай шийдвэр гаргавал танд оршин суух эрхийн карт үйлдвэрлэн элчин сайдын яам руу илгээнэ. Элчин сайдын яаманд таны карт ирсэн тохиолдолд тантай холбоо барих бөгөөд та ирж авах боломжтой. Та сурах хугацаагаа дууссаны дараа Швед улсаас гарах ёстой. Та Швед улсад хичнээн ч олон жил суралцсан Швед улсад үлдэж, оршин суух эрх авах боломж ерөнхийдөө байхгүйг анхаарна уу.

Таны өргөдөлд шаардлагатай бичиг баримт (таны анхааралд: та өргөдөлдөө орж байгаа бүх бичиг баримтыг 1 хувь хуулбартай нь өгөх ёстой.) Та өргөдлийг онлайн-аар тавьж байгаа бол дагалдах бичиг баримтыг бас заавал хавсаргана.

Мөн Цагаачлалын алба болон Элчин сайдын яамнаас шаардаагүй бичиг баримт өгөхгүй байна уу.

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.
- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй бөгөөд энэ нь өргөдөл шийдэгдэх явцыг удаашруулах магадлалтай. (Та баруун талд байгаа жишээ зургийг харна уу).
- 2 хувь паспортын нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол улсын иргэдэд:** Хэрвээ Монгол улсын иргэд оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо элчин сайдын яам руу илгээхгүй байна уу, мөн таны өргөдөл нааштай шийдэгдсэн тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биометр-ээ үлдээнэ үү.
- Таныг орон тооны оюутнаар бүртгэсэн тухай баталгаа эсвэл урилга.
- Хэрвээ та эхлээд хэл сураад дараа нь их дээд сургууль, коллежид сурахаар бол хэлний сургууль, их дээд сургуулийн аль алийнх нь урилга, баталгааг хавсаргана.
- Хэрвээ та оюутан солилцооны хөтөлбөрөөр явж байгаа бол тус сургуулийн танилцуулгын захидал, мөн захидлын хуулбарыг хавсаргана. Захидал англи хэл дээр орчуулагдсан болон албан ёсны гарын үсэг, тамга тэмдэгтэй байх ёстой.
- Хэрвээ та Монгол улсад аль нэгэн дээд сургууль эсвэл компанид ажилладаг бол тус дэд сургууль / компанийн танилцуулгын захидал, мөн захидлын хуулбарыг хавсаргана. Тус захидал та дээд сургууль / компанид ямар албан тушаал эрхэлдэгийг тодорхойлсон байх ба таны ажил олгогчийн хаяг, таны асуудлыг хариуцах хүн хэн болох, ямар утасны дугаартайг заана.
- Санхүүгийн баталгаа. Та 10 сарын хугацаанд (нэг хичээлийн жилд) сар болгон **7300 швед кронтой** болохоо харуулсан банкны гэрчилгээг хавсаргах ёстой. Мөнгө таны өөрийн хувийн дансанд хадгалагдсан байх ёстой. Та Швед улсад байх нийт хугацааны турш хангалттай мөнгөтэй гэдгээ харуулах хэрэгтэй. Санхүүгийн баталгаа англи хэл дээр, 2 хувь байх ёстой.
- Хэрвээ та Швед улсад нэг жилээс доош хугацаагаар сурах бол заавал иж бүрэн эрүүл мэндийн даатгалтай байх ёстой. Даатгал сурахад төлөвлөгдсөн нийт хугацаанд хамаатай байх ба доод тал нь 30000 евро-гийн эмчилгээний болон эрүүл мэндийн шалтгаанаар нутаг буцах зардлыг хангасан байх шаардлагатай.
- Та өргөдлийн төлбөр төлөх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгвөл төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр том хүн **1015 юань**, 18-аас доош насны хүүхэд **505 юань**. Элчин сайдын яаманд зөвхөн картаар тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохилдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлбэл заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Их дээд сургуульд сурах оюутнууд цахим хэлбэрээр анкетаа бөглөж болно. Та "Оюутнууд цахим хэлбэрээр оршин суух эрхийн өргөдөл бөглөх" гэдэг хэсэгт уншина уу. Та цахим хэлбэрээр анкет бөглөсөн нөхцөлд та мөн элчин сайдын яам дээр өөрийн биеэр ирж хувийн ярилцлагад орж, паспорт бусад бичиг баримтын хуулбараа өгөх, анкетан дээрээ гарын үсэг зурах, зургаа авахуулах, гарын хурууны хээгээ үлдээх хэрэгтэй болно. Хурууны хээг оршин суух эрхийн карт үйлдвэрлэхэд хэрэглэх юм.

Хэрвээ шаардсан бичиг баримт бүрэн ирээгүй бол шийдвэр гаргах явц магадгүй удааширна. Элчин сайдын яамнаас нэмэлт бичиг баримт, лавлах мэдээлэл хэрэгтэй бол тантай холбогдоно.

Та анкетан дээрээ тантай хэрхэн эргэн холбогдох мэдээллийг бичиж үлдээх нь чухал. Үлдээгээгүй тохиолдолд элчин сайдын яам таны өргөдөлтэй холбоотой нэмэлт бичиг баримт шаардах эсвэл бусад тантай холбоотой асуудлыг танд мэдэгдэх боломжгүй болно.

Хэрхэн оюутны дагалдагчаар оршин суух эрх хүсэх

Хэрвээ та Швед улс руу тэнд сурч байгаа нөхөр/эхнэр/хамтран амьдрагч/эцэг эх дээрээ түр хугацаагаар очиж амьдрах хүсэлтэй бол та явахаасаа өмнө оршин суух эрх хүсэх ёстой. Та оршин суух эрхийг Бээжинд байрлах Шведийн элчин сайдын яамнаас хүсэж болно. Элчин сайдын яам таны өргөдөлтэй холбоотой бүх бичиг баримтыг бүрдүүлсний дараа материалыг Швед улсын Цагаачлалын алба руу илгээнэ.

Цагаачлалын албанаас нааштай шийдвэр гарсны дараа танд оршин суух эрхийн карт үйлдвэрлэгдэж элчин сайдын яам руу илгээгдэнэ. Элчин сайдын яам таны картыг хүлээж авсны дараа тантай холбогдох бөгөөд та ирж оршин суух эрхийн картаа авч болно. Та Швед улс руу зорчин, хариуг тэнд хүлээж болохгүй.

Та өргөдөлдөө дараах бичиг баримт багтаана (таны анхааралд: таны өргөдөлд орж байгаа бүх бичиг баримт 1 хувь хуулбартай байх ёстой).

Мөн Цагаачлалын алба болон Элчин сайдын яамнаас шаардаагүй бичиг баримт өгөхгүй байна уу.

Хэрвээ таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагч Шведэд байгаа бол:

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет.
- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй болон энэ нь өргөдөл шийдэгдэх явцыг удаашруулах магадлалтай.
- 2 хувь паспортын нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол улсын иргэдэд:** Хэрвээ Монгол улсын иргэд оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо элчин сайдын яам руу илгээхгүй байна уу, мөн таны өргөдөл нааштай шийдэгдсэн тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биометр-ээ үлдээх ёстой.
- Нотариатаар баталгаажуулсан гэрлэлтийн гэрчилгээ, хуулбарын хамт, эсвэл та Швед улсад гэрлэсэн бол Шведийн гэрлэлтийн гэрчилгээ (vigselsbevis) 2 хувь.
- Хэрвээ та гэрлэж байгаагүй эсвэл салсан бол таныг ганц бие болохыг харуулсан нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ хавсаргах (эх хувь болон англи хэл дээрх орчуулга). Энэ нь ямар нэгэн тодорхойлолт, мэдэгдэл биш харин гэрчилгээ байх ёстойг анхаарна уу. **Монгол улсын иргэдэд:** Бичиг баримтыг Улаанбаатар дахь Гадаад явдлын яамаар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.
- таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчийн паспортын нүүр хуудасны хуулбар 2 хувь.
- таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчийн хүн амын бүртгэлийн гэрчилгээ "personbevis" 2 хувь.
- таны нөхөр/эхнэр/хамтран амьдрагчаас гаргасан урилга.
- Санхүүгийн баталгаа. Та сар болгон ойролцоогоор 3500 швед кронтой болохоо харуулах ёстой.
- Та өргөдлийн төлбөр төлөх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгвөл төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр **1015 юань** бөгөөд элчин сайдын яаманд зөвхөн картаар тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлбэл заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Эцэг эхийн аль нэг нь эсвэл 2-уулаа Шведэд байгаа (18-аас доош насны) хүүхэд эсвэл эцэг эхээ дагалдан Швед улс руу яваа хүүхэд:

- 2 хувь бүрэн бөглөсөн гарын үсэгтэй анкет. Мөн анкетанд хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч гарын үсэг зурна.

- 2 хувь сүүлийн 6 сард авахуулсан засваргүй зураг. Болзол хангаагүй зураг хүлээж авахгүй болон энэ нь өргөдөл шийдэгдэх явцыг удаашруулах магадлалтай. Зургийн шаардлага хэрхэн хангахыг photo guidelines гэдгээс харж болно.
- 2 хувь паспортын нүүр хуудас харуулсан хуулбар. Бид зөвхөн эзэмшигчийн гарын үсэгтэй паспорт хүлээж авна. **Тайлбар Монгол улсын иргэдэд:** Хэрвээ Монгол улсын иргэд оршин суух эрх хүсэж байгаа бол паспортоо элчин сайдын яам илгээхгүй байна уу, мөн таны өргөдөлд нааштай шийдвэр гарсан тохиолдолд та заавал өөрийн биеэр элчин сайдын яаманд ирж биомэтр-ээ үлдээнэ үү.
- Нотариатаар баталгаажуулсан төрсний гэрчилгээ, нэг хувь хуулбарын хамт. *Монгол улсын иргэдэд: бичиг баримтаа Улаанбаатар дахь Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- Хэрвээ хүүхэд ганц харгалзагчтай бол хүүхдийн албан ёсны харгалзагч хэн болохыг заасан нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ, мөн гэрчилгээний хуулбар шаардлагатай. *Монгол улсын иргэдэд: бичиг баримтыг Улаанбаатар дахь Гадаад явдлын яамны Консулын газраар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- Хүүхдийн аль нэг харгалзагч Монгол улсад байгаа тохиолдолд хүүхдээ Швед улс руу амьдрахаар явж байгааг мэдэж байгаа болон Швед улс руу явахыг зөвшөөрсөн гэсэн нотариатаар баталгаажуулсан гэрчилгээ, мөн гэрчилгээний хуулбар. *Монгол улсын иргэд: бичиг баримтаа Улаанбаатар дахь Гадаад явдлын яамаар баталгаажуулж, англи хэл дээр орчуулуулна.*
- эцэг эхийн паспортны нүүр хуудас харуулсан хуулбар 2 хувь.
- эцэг эхийн хүн амын бүртгэлийн гэрчилгээ "personbevis", хуулбарын хамт.
- Шведэд байгаа эцэг эхийн урилга.
- Санхүүгийн баталгаа. Та сар болгон ойролцоогоор 2100 швед кронтой болохоо харуулна.
- Та өргөдлийн төлбөр төлөх шаардлагатай. Хэрвээ таны өргөдөлд татгалзсан хариу өгсөн бол төлбөрийг нөхөн олгохгүй. Өргөдлийн төлбөр 18-аас доош насны хүүхдэд одоогоор **505 юань** бөгөөд Элчин сайдын яаманд зөвхөн картаар тооцоо хийнэ (Хятадын банкны карт). Картаар төлөх ямар ч боломжгүй тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөр хийхийг зөвшөөрнө. Хэрвээ шуудангаар мөнгө ирүүлбэл заавал хятад мөнгөн тэмдэгт байх бөгөөд яг тааруулж явуулсан байх шаардлагатай.

Хэрвээ шаардсан бичиг баримт ирээгүй бол шийдвэр гаргах явц магадгүй удааширна. Элчин сайдын яамнаас нэмэлт бичиг баримт болон лавлах мэдээлэл хэрэгтэй бол тантай холбогдоно.

Та анкетан дээрээ тантай эргээд холбогдох мэдээлийг бичиж үлдээх нь чухал. Үлдээгээгүй тохиолдолд элчин сайдын яамнаас таны өргөдөлтэй холбоотой бичиг баримт шаардахад эсвэл бусад тантай холбоотой асуудлыг танд мэдэгдэх боломжгүй болно.

Онлайнаар өргөдөл гаргах үйлчилгээ

2011-12-07-ноос эхлэн Швед улсын бүх элчингүүдэд онлайнаар гэр бүлийн хамаарлаар оршин суух эрх хүсэх үйлчилгээ бий болсон билээ. Энэ шинэ үйлчилгээг Шведийн Цагаачлалын алба хариуцах бөгөөд энэ нь өргөдөл боловсруулах үйл ажилгааг маш их хялбарчилсан юм.

Өргөдлийн бичиг баримтыг цахим хэлбэрээр шийдвэр гаргуулахаар шилжүүлэх бөгөөд энэ нь элчин сайдын яамдын ажиллагааг хурдасгах юм. Одоогоор шийдвэр гарахыг хүлээх хугацаа дунджаар 7-9 сар байна. Хэрвээ та онлайнаар өргөдөл гаргавал дээрх хугацааны зөвхөн тал нь шаардагдана.

Цахим хэлбэрээр хэн өргөдөл гаргаж болох вэ?

Онлайнаар өргөдөл гаргахын тулд:

- Та шинэхэн эхэлсэн харьцаа, тогтсон харьцаа эсвэл нэг өрхийн амьдралтай гэдгийн аль нэгийг харуулж өргөдөл гаргана.
- Та доод тал нь 18-тай байх ёстой бөгөөд хүчинтэй иргэний паспорттай байх ёстой.

Таны хамааралтай хүн зайлшгүй:

- Швед улсын иргэн эсвэл Швед улсад байнгын оршин суух эрхтэй байх ёстой.
- Доод тал нь 18 настай байх ёстой.

Хэрхэн өргөдөл гаргах

Цахим хэлбэрээр өргөдөл гаргахад:

- Анкетийг бүрэн бөглөнө
- Бүх хэрэгцээтэй бичиг баримтыг хавсаргах
- Өргөдлийн хураамжийг цахим хэлбэрээр төлөх
- Өргөдлөө Шведийн Цагаачлалын алба руу цахим хэлбэрээр илгээх

Тус өргөдлийг Цагаачлалын алба хүлээж аваад Швед улсад байгаа таны хамааралтай хүн рүү цахим шуудан явуулан түүнд бөглүүлэх онлайн анкетийн талаар, анкетанд хэрхэн нэвтрэх зааварчилгааг өгнө.

Шведийн Цагаачлалын алба таны өргөдөл болон таны хамааралтай хүний бөглөсөн анкетийг авсны дараа өргөдөл боловсруулалтын ажиллагаа эхлэнэ.

- Таныг хамгийн ойрын Шведийн элчин сайдын яамтай ярилцлага захиалахыг хүснэ. Цаг захиалахад Цагаачлалын албаны вэб-сайтаар захиалах эсвэл та элчин сайдын яамны ажилтныг тантай холбогдож цаг товлохыг хүлээх хэрэгтэй. Энэ талаар та элчин садын яаманд мейл илгээх шаардлагагүй.
- Бичиг баримтыг элчин сайдын яам шалгаж, тайлан бэлтгэнэ.
- Зураг болон гарын хурууны хээг уулзалтын үеэр авах бөгөөд энэ нь таны оршин суух эрхийн картанд хэрэглэгдэх юм.
- Элчин сайдын яам материалыг Цагаачлалын алба руу шийдвэр гаргуулахаар илгээнэ.

Цагаачлалын албаны дараах вэб-сайтаас цахим хэлбэрээр оршин суух хүсэх эсвэл бусад мэдээлэлийг авна уу:

http://www.migrationsverket.se/info/4386_en.html